ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Ерөнхий боловсролын "Чандмань-Эрдэнэ" сургуулийн 2025 оны санхүүгийн аудитын хураангуйтайлан

**Аудитын код:** ЗАА-2026/138/НА-СТА-ТШЗ


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

"Алтан-Тосон аудит" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: altantosonaudit@gmail.com


Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ


ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улиастай сум, Завхан аймаг 81090
Утас/Факс:7046-36-12
Цахим шуудан: zavkhan@audit.gov.mn


2026.02.12 № 98

танай ........ -ны № ........ т

УЛИАСТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН "ЧАНДМАНЬ-ЭРДЭНЭ" СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ХОРОЛГАРАВ-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Ерөнхий боловсролын "Чандмань-Эрдэнэ" сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Ерөнхий боловсролын "Чандмань-эрдэнэ" сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Ерөнхий боловсролын "Чандмань-эрдэнэ" сургууль нь нөхөн хангалтын зардлаас 74,705,600 төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, Мобиком корпорацаас иж бүрэн смарт анги тохижуулалтад 145,035,638 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнийг бүртгэлд тусгасан ажилласан байна. Монголын цахилгаан холбооны утасгүй интернэтийн төлбөрийн үлдэгдэл 15,224,479 төгрөгийн өглөгийг бүрэн төлж барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Улиастай сумын Ерөнхий боловсролын "Чандмань-эрдэнэ" сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан хаагчид ээлжийн амралт, цалин болон албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны зардлыг давхардуулан олгосон, сургуулийн захиралд үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг илүү тооцож олгосон, тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөөгүй

хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцолгүй, хийсэн ажлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй, алба хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг тооцож олгохдоо Засгийн газрын 382 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.1, 3.3 дахь заалтыг баримтлаагүй, "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтөлж, илүү цагаар хийсэн ажлыг баримтжуулаагүй, мөн өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Улиастай сумын Ерөнхий боловсролын "Чандмань-Эрдэнэ" сургуулийн багш нарт аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар Монгол Улсын Боловсролын Их сургууль, Эрдэмтэн сурагчдын хөгжлийн институт, Монголын хүний нөөц удирдлага шинэчлэлийн хүрээлэн, "Гоц ивээл академи" төрийн бус байгууллага болон бусад чиглэлээр математик, мэдээлэл технологи, судлагдахуйн сургалтуудыг авч, 9,609,000 төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр/)*

| | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 787,221,121.28 | 433,314,813.20 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 495,639,786.42 | 116,558,385.01 |
| 8 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 495,639,786.42 | 116,558,385.01 |
| 9 | Төгрөг | 495,639,786.42 | 116,558,385.01 |
| 10 | Төрийн сангийн харилцах | 495,639,786.42 | 116,558,385.01 |
| 27 | АВЛАГА | (0.00) | 2,276,306.31 |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | (0.00) | 2,270,806.33 |
| 34 | Бусад авлага | - | 5,499.98 |
| 35 | Байгууллагаас авах авлага | - | 5,499.98 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 291,581,334.86 | 314,480,121.88 |
| 61 | Түүхий эд материал | 132,900.00 | - |
| 62 | Тусгай зориулалттай материал | 132,900.00 | - |
| 65 | Бэлэн бүтээгдэхүүн | 152,793,172.08 | 126,270,320.00 |
| 66 | Хангамжийн материал | 138,655,262.78 | 188,209,801.88 |
| 67 | Бичиг хэргийн материал | 2,632,000.00 | 760,000.00 |
| 68 | Аж ахуйн материал | 4,064,500.00 | 3,308,500.00 |
| 71 | Барилгын засварын материал | - | 3,462,300.00 |
| 72 | Хүнсний материал | 533,121.72 | 50,001.72 |
| 73 | Бусад хангамжийн материал | 131,225,641.06 | 180,629,000.16 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,529,876,506.09 | 2,547,771,059.86 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,529,876,506.09 | 2,547,771,059.86 |
| 108 | Биет хөрөнгө | 2,207,532,370.09 | 2,225,426,923.86 |
| 109 | Барилга, байгууламж | 1,597,921,102.00 | 1,597,921,102.00 |
| 110 | Хуримтлагдсан элэгдэл | (214,292,007.62) | (240,398,217.02) |
| 111 | Машин, тоног төхөөрөмж | 574,842,585.62 | 685,529,374.72 |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | (170,810,064.88) | (278,578,134.08) |
| 113 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 273,687,185.30 | 312,230,520.20 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (53,896,896.34) | (88,373,589.61) |
| 115 | Бусад үндсэн хөрөнгө | 123,723,348.00 | 123,723,348.00 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (8,226,822.90) | (17,182,958.34) |
| 117 | Номын фонд | 100,380,548.91 | 146,352,085.99 |
| 118 | Биет бус хөрөнгө | 322,344,136.00 | 322,344,136.00 |
| 119 | Програм хангамж | 4,470,950.00 | 4,470,950.00 |
| 120 | Хасагдуулга | (4,470,950.00) | (4,470,950.00) |
| 121 | Бусад биет бус хөрөнгө | 322,344,136.00 | 322,344,136.00 |
| 122 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 3,317,097,627.37 | 2,981,085,873.06 |
| 123 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 81,444,587.83 | 38,825,552.86 |
| 124 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 81,444,587.83 | 38,825,552.86 |
| 125 | Өглөг | 81,444,587.83 | 38,825,552.86 |
| 126 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | - | 0.00 |
| 127 | Бусад өглөг | 81,444,587.83 | 38,825,552.86 |
| 128 | Байгууллагад төлөх өглөг | 76,306,337.83 | 38,825,552.86 |
| 129 | Хувь хүмүүст төлөх өглөг | 5,138,250.00 | - |
| 130 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 3,205,705,914.45 | 2,912,313,195.11 |
| 131 | Засгийн газрын хувь оролцоо | 3,205,705,914.45 | 2,912,313,195.11 |

| | | | |
|---|---|---|---|
| 132 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 822,278,382.84 | 822,278,382.84 |
| 133 | Өмч: -Төрийн өмч | 822,278,382.84 | 822,278,382.84 |
| 134 | Хуримтлагдсан үр дүн | 464,770,065.06 | 171,377,345.72 |
| 135 | Өмнөх үеийн үр дүн | 464,770,065.06 | 464,770,065.06 |
| 136 | Тайлант үеийн үр дүн | - | (293,392,719.34) |
| 137 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,918,657,466.55 | 1,918,657,466.55 |
| 138 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 3,287,150,502.28 | 2,951,138,747.97 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 4,665,134,234.00 | 4,440,823,643.08 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 467,273,334.00 | 254,757,275.08 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 467,273,334.00 | 254,757,275.08 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 458,300,434.00 | 254,457,275.08 |
| 82 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,818,942.00 | 42,890,100.00 |
| 83 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,481,000.00 | - |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 440,000,492.00 | 211,567,175.08 |
| 92 | Бусад орлого | 8,972,900.00 | 300,000.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,197,860,900.00 | 4,186,066,368.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,801,238,500.00 | 3,777,386,300.00 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,801,238,500.00 | 3,777,386,300.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 396,622,400.00 | 408,680,068.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 396,622,400.00 | 408,680,068.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 3,867,110,167.11 | 4,734,076,362.42 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,867,110,167.11 | 4,734,076,362.42 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,691,808,716.93 | 4,456,126,665.21 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 2,600,055,868.07 | 3,216,221,469.31 |
| 151 | Цалин | 1,736,530,072.40 | 1,762,991,440.18 |
| 152 | Нэмэгдэл цалин | 736,850,402.65 | 1,453,230,029.13 |
| 154 | Урамшуулал | 126,675,393.02 | - |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 360,264,423.00 | 412,297,700.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 247,399,700.00 | 286,662,179.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 29,105,900.00 | 31,893,439.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 14,553,000.00 | 63,786,879.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 14,553,000.00 | 6,378,690.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 54,652,823.00 | 23,576,513.00 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 394,232,625.64 | 376,156,826.99 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 21,818,737.64 | 34,668,753.13 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 297,306,438.00 | 284,299,368.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 75,107,450.00 | 57,188,705.86 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | - | 53,354,306.98 |
| 178 | Бараа материал актасны зардал | - | 53,354,306.98 |
| 181 | Нормативт зардал | 35,487,550.00 | 46,580,545.00 |
| 183 | Хоол | 35,487,550.00 | 46,580,545.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 100,000.00 | 7,158,400.00 |
| 189 | Урсгал засвар | 100,000.00 | 7,158,400.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 48,722,799.94 | 67,123,760.96 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,604,600.00 | - |
| 200 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 37,118,199.94 | 67,123,760.96 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 252,945,450.28 | 277,233,655.97 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 67,328,380.00 | 78,357,748.66 |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 29,370,840.00 | 21,568,800.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 156,246,230.28 | 177,307,107.31 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 175,301,450.18 | 277,949,697.21 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 175,301,450.00 | 258,401,900.00 |
| 232 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 175,301,450.00 | 258,401,900.00 |
| 241 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.18 | 19,547,797.21 |
| 244 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.18 | 19,547,797.21 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 798,024,066.89 | (293,252,719.34) |
| 276 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 100,983,633.42 | 140,000.00 |
| 277 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 58,803,933.42 | - |
| 281 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 42,179,700.00 | 140,000.00 |
| 287 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | (100,983,633.42) | (140,000.00) |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 697,040,433.47 | (293,392,719.34) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *|төгрөгөөр|*

| | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 4,225,133,742.00 | 4,229,256,468.00 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 27,272,842.00 | 43,190,100.00 |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 27,272,842.00 | 43,190,100.00 |
| 82 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 18,299,942.00 | 42,890,100.00 |
| 83 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,818,942.00 | 42,890,100.00 |
| 84 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 11,481,000.00 | - |
| 92 | Бусад орлого | 8,972,900.00 | 300,000.00 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,197,860,900.00 | 4,186,066,368.00 |
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,801,238,500.00 | 3,777,386,300.00 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,801,238,500.00 | 3,777,386,300.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 396,622,400.00 | 408,680,068.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 396,622,400.00 | 408,680,068.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,775,301,490.02 | 4,567,667,169.41 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,775,301,490.02 | 4,567,667,169.41 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,605,809,239.84 | 4,291,461,472.20 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 2,598,833,161.42 | 3,219,006,026.45 |
| 151 | Үндсэн цалин | 1,735,307,765.75 | 1,956,443,997.61 |
| 152 | Нэмэгдэл | 736,850,402.65 | 962,760,790.82 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 110,710,208.34 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 126,674,993.02 | 189,091,029.68 |
| 157 | Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 360,264,423.00 | 412,297,700.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 247,399,700.00 | 280,362,700.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 29,105,900.00 | 32,983,900.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 14,553,000.00 | 16,491,900.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 14,553,000.00 | 16,491,900.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 54,652,823.00 | 65,967,300.00 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 391,622,399.82 | 378,511,570.79 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 22,917,552.32 | 37,023,496.93 |
| 166 | Түлш, халаалтын зардал | 294,477,397.50 | 284,299,368.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 74,227,450.00 | 57,188,705.86 |
| 181 | Нормативт зардал | 34,939,050.00 | 46,097,425.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 183 | Хоол, хүнс | 34,939,050.00 | 46,097,425.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,000,000.00 | 10,620,700.00 |
| 189 | Урсгал засвар | 5,000,000.00 | 10,620,700.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 82,604,997.60 | 67,123,760.96 |
| 195 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 11,604,600.00 | - |
| 200 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 71,000,397.60 | 67,123,760.96 |
| 206 | Бараа үйлчилгээний бусад зардал | 132,545,206.00 | 157,804,289.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100,471,468.00 | 136,235,489.00 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 32,073,740.00 | 21,568,800.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 169,492,250.18 | 276,205,697.21 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 169,492,250.00 | 256,657,900.00 |
| 229 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал | 169,492,250.00 | 256,657,900.00 |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.18 | 19,547,797.21 |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.18 | 19,547,797.21 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 449,832,251.98 | (338,410,701.41) |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 74,716,800.00 | 40,670,700.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 74,716,800.00 | 40,670,700.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 74,716,800.00 | 40,670,700.00 |
| 266 | Тоног төхөөрөмж | - | 25,375,700.00 |
| 267 | Бусад хөрөнгө | - | 15,295,000.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 74,716,800.00 | - |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (74,716,800.00) | (40,670,700.00) |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 375,115,451.98 | (379,081,401.41) |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 120,524,334.44 | 495,639,786.42 |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 495,639,786.42 | 116,558,385.01 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | ДАНС | 511 | 51300 | 512 | |
| 2 | 2024 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл | 614,328,382.84 | 1,009,112,117.15 | -555,114,199.42 | ,106,8326,300.56 |
| 4 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 614,3283,82.84 | 1,009,112,117.15 | -555,114,199.42 | ,1068,326,300.56 |
| 8 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 20,7950,000.00 | 0 | -6,0862,132.74 | 147,087,867.26 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 82,2278,382.84 | 1,918,657,466.55 | - 232,270,368.41 | 2,508,665,480.98 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 822,278,382.84 | 1,918,657,466.55 | - 232,270,368.41 | ,2508,665,480.98 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 822,278,382.84 | 1,918,657,466.55 | - 232,270,368.41 | ,2508,665,480.98 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 0 | 0 | - 293,392,719.34 | -293,392,719.31 |
| 18 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | , 822278,382.84 | 1,918,657,466.55 | - 525,663,087.75 | 2,215,272,761.64 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *(төгрөгөөр)*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 495,639,786.42 | (495,639,786.42) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,776,950,900.00 | 4,567,667,169.41 | 209,283,730.59 | 90.00 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 4,776,950,900.00 | 4,567,667,169.41 | 209,283,730.59 | 90.00 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 4,507,610.800 | 4,291,461,472.20 | 216,149,327.8 | 95.20 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,311,371,100.00 | 3,219,006,026.45 | 92,365,073.5 | 97.21 |
| 6 | Үндсэн цалин | 2,160,165,700.00 | 1,956,443,997.61 | 203,721,702.39 | 90.05 |
| 7 | Нэмэгдэл | 1,038,588,100.00 | 962,760,790.82 | 75,827,309.18 | 92.69 |
| 8 | Унаа, хоолны хөнгөлөлт | 0.00 | 110,710,208.34 | (110,710,208.34) | 0.00 |
| 9 | Урамшуулал | 112,617,300.00 | 189,091,029.68 | (76,473,729.60) | 167.90 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 414,135,700.00 | 412,297,700.00 | 1,838,000.00 | 0.90 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 281,612,300.00 | 280,362,700.00 | 1,249,600.00 | 99.55 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 33,130,900.00 | 32,983,900.00 | 147,000.00 | 99.55 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 16,565,400.00 | 16,491,900.00 | 73,500.00 | 99.55 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 16,565,400.00 | 16,491,900.00 | 73,500.00 | 99.55 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 66,261,700.00 | 65,967,300.00 | 294,400.00 | 99.55 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 438,487,900.00 | 418,940,102.79 | 19,547,797.21 | 95.54 |
| 18 | Гэрэл цахилгаан | 43,126,700.00 | 37,023,496.93 | 6,103,203.07 | 85.84 |
| 19 | Түлш, халаалт | 314,107,200.00 | 314,107,200.00 | - | 100.00 |
| 20 | Цэвэр, бохир ус | 74,254,000.00 | 57,188,705.86 | 17,065,294.14 | 77.01 |
| 30 | Нормативт зардал | 52,322,100.00 | 46,097,425.00 | 6,224,675.00 | 80.00 |
| 32 | Хоол, хүнс | 52,322,100.00 | 46,097,425.00 | 6,224,675.00 | 88.10 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 7,000,000.00 | 10,620,700.00 | (3,620,700.00) | 150.00 |
| 38 | Урсгал засвар | 7,000,000.00 | 10,620,700.00 | (3,620,700.00) | 150.00 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 70,440,200.00 | 67,123,760.96 | 3,316,439.04 | 95.29 |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 70,440,200.00 | 67,123,760.96 | 3,316,439.00 | 95.29 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 220,402,000.00 | 157,804,289.00 | 62,597,711.00 | 70.00 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 198,833,200.00 | 136,235,489.00 | 62,597,711.00 | 68.51 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,568,800.00 | 21,568,800.00 | 0.00 | 100.00 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 269,340,100.00 | 276,205,697.21 | (6,865,597.21) | 102.54 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 269,340,100.00 | 256,657,900.00 | 12,682,200.00 | 95.29 |
| 74 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 269,340,100.00 | 256,657,900.00 | 12,682,200.00 | 95.29 |
| 79 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 19,547,797.21 | (19,547,797.21) | - |
| 81 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 19,547,797.21 | (19,547,797.21) | - |
| 83 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 40,670,700.00 | (40,670,700.00) | - |
| 84 | Дотоод эх үүсвэрээр | - | 40,670,700.00 | (40,670,700.00) | - |
| 87 | Тоног төхөөрөмж | - | 25,375,700.00 | (25,375,700.00) | - |
| 88 | Бусад хөрөнгө | - | 15,295,000.00 | (15,295,000.00) | - |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 4,776,950,900.00 | 4,259,064,300 | 517,824,900.00 | 87.94 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,295,211,200.00 | 3,777,386,300 | 517,824,900.00 | 87.94 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 4,295,211,200.00 | 3,777,386,300 | 517,824,900.00 | 87.94 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 438,487,900.00 | 438,487,900.00 | - | 100.00 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 438,487,900.00 | 438,487,900.00 | - | 100.00 |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 42,800,000.00 | 43,190,100.00 | (390,100.00 ) | 101.00 |
| 111 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 35,800,000.00 | 38,090,100.00 | (2,290,100.00) | 106.00 |
| 112 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,000,000.00 | 5,100,000.00 | 1,900,000.00 | 72.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 495,639,786.42 | (495,639,786.42) | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 116,558,385.01 | (116,558,385.01) | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31* *./төгрөгөөр/*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 200 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 438,487,900.00 | 418,940,102.79 | 19,547,797.21 | 100.00 |
| 201 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 438,487,900.00 | 418,940,102.79 | 19,547,797.21 | 100.00 |
| 202 | Бараа, үйлчилгээний зардал | 438,487,900.00 | 418,940,102.79 | 19,547,797.21 | 100.00 |
| 215 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 438,487,900.00 | 418,940,102.79 | 19,547,797.21 | 100.00 |
| 216 | Гэрэл цахилгаан | 43,126,700.00 | 37,023,496.93 | 6,103,203.07 | 85.84 |
| 217 | Түлш, халаалт | 314,107,200.00 | 314,107,200.00 | 0.00 | 100 |
| 218 | Цэвэр, бохир ус | 74,254,000.00 | 57,188,705.86 | 17,065,294.14 | 77.01 |
| 232 | Эд хогшил худалдан авах | 7,000,000.00 | 10,620,700.00 | (3,620,700.00) | 151.72 |
| 236 | Урсгал засвар | 7,000,000.00 | 10,620,700.00 | (3,620,700.00) | 151.72 |
| 298 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 19,547,797.21 | (19,547,797.21) | - |
| 299 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | - | 19,547,797.21 | (19,547,797.21) | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1765 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 438,487,900.00 | 438,487,900.00 | - | 100.00 |
| 1771 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 438,487,900.00 | 438,487,900.00 | - | 100.00 |
| 1772 | Орон нутгийн төсвөөс | 438,487,900.00 | 438,487,900.00 | - | 100.00 |

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 55,996.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 37,667.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 2,556.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15,772.9 мянган төгрөгийн зөрчилд 3 заалт зөвлөмж, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн.

**3.1 Залруулсан алдаа:** Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 37,667.3 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд дутуу тусгаж, өглөг бууруулан бичилт хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д "Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.", 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**.3.2 Төлбөрийн акт:**

Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 165.0 мянган төгрөгийн хоолны зардлыг, багш, ажилтнуудад 539.5 мянган төгрөгийн ээлжийн амралтын мөнгө, цалинг, захиралд 1,303.9 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус давхардуулан олгосон, 1 албан хаагчид 548.1 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

**3.3 Албан шаардлага:**

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага өгсөн.

**3.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой***

***Илрүүлэлт:*** Багш хөгжлийн бүлэгт олгосон 2,980.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, чиглүүлэгч багш нарт 3,561.6 мянган төгрөгийн нэмэгдэл хөлсийг хийсэн ажлын тайлан, гарсан үр дүнг тооцоогүй, нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Багш хөгжлийн бүлэгт олгосон бичиг хэргийн материал, багш хөгжлийн бүлгийн болон чиглүүлэгч багш нарт олгосон нэмэгдэл хөлсний нотлох баримтуудыг бүрэн бүрдүүлэх, цаашид анхан шатны баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ гаргахгүй байх;

***2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой***

***Илрүүлэлт:*** Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөөгүй, хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцоогүй, хийсэн ажил нь тодорхойгүй, хичээлд суугаагүй тохиолдолуудыг бүртгэж тооцоо хийгээгүй, хийсэн ажлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй, дутуу баримтаар 6,240.1 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг журамд заасны 10 хувиар тооцож олгох, анхан шатны нотлох баримтуудыг бүрэн бүрдүүлж хэвших;

***3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой***

***Илрүүлэлт:*** Албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл 2,991,209 төгрөгийн хөлсийг тооцож олгохдоо, илүү цагаар хийсэн ажлыг баримтжуулаагүйгээр олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Засгийн газрын 382 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.1, 3.3 дахь заалтттай нийцэхгүй, байна.

**Өгсөн зөвлөмж:** Алба хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг тооцож олгохдоо, илүү цагаар хийсэн ажлыг баримтжуулж, "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөж олгож байх;

Энэхүү зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 37,667.4 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд дутуу тусгаж, өглөг бууруулан бичилт хийсэн.. | 1 | 37,667.4 | | | 1 | 37,667.4 | 1 | 37,667.4 | | | | |
| **Дүн** | **1** | **37,667.4** | | | **1** | **37,667.4** | **1** | **37,667.4** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Албан томилолтоор ажилласан албан хаагчдад 165.0 мянган төгрөгийн хоолны зардлыг давхардуулан олгосон байна. | 1 | 165.0 | 1 | 165.0 | | | | | | | | |
| Албан хаагчид томилогдсон өдрөөс ажилласан хоногийн зөрүүг тооцолгүй 548.1 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон. | 1 | 548.1 | 1 | 548.1 | | | | | | | | |
| Алба хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг тооцож олгохдоо Засгийн газрын 382 тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.1, 3.3 дахь заалтыг баримтлаагүй, "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөж илүү цагаар хийсэн ажлаа баримтжуулаагүйгээр олгосон. | 1 | 2,991.2 | | | | | 1 | 2,991.2 | | | | |
| Албан хаагчид 539.5 мянган төгрөгийн ээлжийн амралт, цалин давхардуулан олгосон. | 1 | 539.5 | 1 | 539.5 | | | | | | | | |
| Захиралд 1,303,870 төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус давхардуулан олгосон.. | 1 | 1,303.9 | 1 | 1,303.9 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тусгай хэрэгцээтэй хүүхдийг хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээ үзүүлж байгаа арга зүйч, багш, туслах багш, нийгмийн ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг хүүхдэд чиглэсэн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, хүүхдэд гарсан ахиц дэвшил, үр дүнг тооцоогүй , хийсэн ажил нь тодорхойгүй, хичээлд суугаагүй тохиолдолуудыг бүртгэж тооцоо хийгээгүй, хийсэн ажлын нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй, дутуу баримтаар 6,240.1 мянган төгрөгийн нэмэгдлийг олгосон. | 1 | 6,240.1 | | | | | 1 | 6,240.1 | | | | |
| Багш хөгжлийн бүлэгт олгосон 2,980.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалын зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, чиглүүлэгч багш нарт нэмэгдэл хөлсийг хийсэн ажлын тайлан, гарсан үр дүнг тооцож олгоогүй, нотлох баримтыг бүрэн бүрдүүлээгүй 3,561.6 мянган төгрөг олгосон. | 1 | 6,541.6 | | | | | 1 | 6,541.6 | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг цэгцлэх арга хэмжээ авч ажиллаагүй, өмнөх оны санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| **Нийт дүн** | **8** | **18,329.4** | **4** | **2,556.5** | **1** | **-** | **3** | **15,772.9** | | | | |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АХЛАХ АУДИТОР Ц.ОЮУНСУВД

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2026-02-24

БОЛОВСРУУЛСАН:

"АЛТАН ТОСОН АУДИТ" ХХК-ИЙН

АУДИТОР Ж.ТУНГАЛАГ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2025-02-24